



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/597

Арвайхээр

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
олгох тухай

Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 251, 252, 253, 256 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Арвайхээр сумын иргэн С.Дашзэвэгийн “Арвайхээр-Нархан”, Ч.Сарантуяагийн “Дэлгэрэх хөгжлийн гэрэл”, Ж.Дэмбэрэлнинжийн “Бидэнд хайрлагдах зүрх”, Уянга сумын иргэн Б.Тунгалагийн “Нархан мөрөөдлийн хотхон” цэцэрлэгүүдийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2019 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл тус бүр 5 жилийн хугацаатай олгосугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон дээрх байгууллагуудын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101097